

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ 2024 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТЫН
ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГЫН МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 09 дүгээр сарын 30

Улаанбаатар хот

№	Зөрчлийн товч утга №	Дүн мян.төг	Өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Биелэлт
1	2	3	4	5	6
1.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧИЛ					
1.1АЛБАН ШААРДЛАГА-2					
1.	№ 134/A0171238 СНАГ-2025/178/НА-СТА-ТШЗ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардлаас зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 16,200.0 мянган төгрөгийн танхимын түрээсийн зардлыг санхүүжүүлсэн байна.	16,200	-Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллын дагуу ажил гүйлгээг санхүүжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх; - Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт даалгав.	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардлаас танхимын түрээсийн зардлыг санхүүжүүлээгүй. Тайлант хугацаанд аудитын албан шаардлагыг биелэлтийг хангаж ажиллаа.	100%
2.	№ 135/A0171238 СНАГ-2025/178/НА-СТА-ТШЗ Хөтөлбөр арга хэмжээний батлагдсан төсөвт тусгагдаагүй дараах зардлуудыг гаргасан байна. Үүнд: -хүний нөөцийн судалгааны зардал цахим шилжилт арга хэмжээнээс, -гэрээт ажилчдын цалин болон ахмад настанд хүндэтгэл үзүүлэхтэй холбоотой санхүүжилт үндсэн үйл ажиллагаанаас	157,776.8	-Төсөвт батлагдаагүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх; - Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт даалгав.	Аудитын өгсөн албан шаардлагын дагуу гэрээт ажилтнуудыг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 13-ны Б/30 дугаар тушаал, 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Б/47 дугаар тушаалаар тус тус чөлөөлсөн. Ахмад настанд хүндэтгэл үзүүлэхтэй холбоотой санхүүжилтийг 2026 оны төсвийн төсөлд тусгасан. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг болон албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
Албан шаардлагын дүн		173,976.8 /нэг зуун далан гурван сая есөн зуун далан зургаан мянга, найман зуу/			

1.2.ЗӨВЛӨМЖ-3					
1.	Урсгал төсвөөс худалдан авсан бараа материалыг орлого авалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.	38,650.0	Ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, хөрөнгө, бараа материалыг цаг хугацаанд нь данс бүртгэлд тусгаж ажиллах	Худалдан авсан бараа материалыг данс бүртгэлд тусгаж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаа.	100%
2.	Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр арилжааны банканд данс нээсэн, орлого, зарлагын гүйлгээ гаргасан байна.	8,360.0	-Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр арилжааны банканд данс нээхгүй байх	Тус арилжааны банкны дансаар 2024 оны 2-р сараас хойш гүйлгээ хийгээгүй бөгөөд 2025 оны 01 сарын 20-ны өдрийн 03/131, 03/130 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлж дансыг хаасан. Тайлант онд арилжааны банкаар орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаа.	100%
3.	Батлагдсан төсөвт тусгагдаагүй, тайлант онд хэрэгжих боломжгүй нээлттэй мэдээллийн систем shilen.gov.mn-ий хөгжүүлэлтийн үйлчилгээг санхүүжүүлэн урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн байна.	19,950.0	-Тайлант онд хэрэгжихгүй ажил гүйлгээг төсвийн жил дамнуулан зарцуулахгүй байх	2024 онд байгуулсан “Нээлттэй мэдээллийн систем shilen.gov.mn-ийн хөгжүүлэлтийн үйлчилгээ”-ний гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлээр улирал бүр тайланг хүлээн авч НББ-ийн тухай хууль, стандартын дагуу бүртгэж тайлагнасан. 2025 онд төсвийн жил дамнах ажил үйлчилгээг санхүүжүүлээгүй.	100%
Зөвлөмжийн нийт дүн		66,960.00 /жаран зургаан сая есөн зуун жаран мянга/			
2.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АСУУДАЛ					
2.1. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ АЛБАН ШААРДЛАГА-1					
1.	№ 136/A0171238 СНАГ-2025/178/НА-СТА-ТШЗ Цалингаас бусад таван саяас дээш зарлагын 4 гүйлгээ мэдээлээгүй, 5 гүйлгээ хугацаа хоцроож мэдээлсэн	26,796.0	- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах байх, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх; - Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төсвийн	Тайлант хугацааны 120 мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулж, ил тод нийтэлсэн байна.	100%

			шууд захирагч, нягтлан бодогч нарт даалгав.		
2.2. БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ АЛБАН ШААРДЛАГА-1					
2.	№ 137/A0171238 СНАГ-2025/178/НА-СТА-ТШЗ Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ижил төстэй ажил, үйлчилгээний төсөвт өртгийг хувааж ажил, үйлчилгээг шууд худалдан авалтын аргаар бэлтгэсэн байна. Үүнд: контент бүтээх 74,300.0 мянган төгрөг, арга хэмжээнд зориулсан тоног төхөөрөмж, хурлын заалны түрээс 294,366.0 мянган төгрөг/	368,666.0	- Ижил төстэй ажил, үйлчилгээний төсөвт өртгийг багцлан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй зөрчлийн таслан зогсоож, ижил төстэй бараа ажил үйлчилгээг худалдан авах зориулалт, нэр төрөл, газарзүйн байрлалыг харгалзан багцалж зохион байгуулж байх, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх; - Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт даалгав.	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоод хяналтыг сайжруулж, худалдан авалтын бүх шатанд хуульд нийцсэн байдлыг баталгаажуулж ажиллаж байна. Контент бүтээх, арга хэмжээний тоног төхөөрөмж болон хурлын заалны түрээс зэрэг ижил төстэй үйлчилгээний төсөвт өртгийг нэгтгэн багцалж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргын А/237 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.	100%
2.3 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ ЗӨВЛӨМЖ-2					
3.	"Аймаг, орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн систем"-ийг 2024 онд 2 аймагт нэвтрүүлсэн бөгөөд ЦХИХХЯ нь эдгээр системүүдийг программ хангамж дансанд бүртгэж, цаашид хэрэгжих аймгуудын цахим шилжилтийн системийн суурь болгон ашиглахаар ажиллаж байгаа ч гэрээнд оюуны өмчийг эзэмших, ашиглах талаар тодорхой заалт тусгаагүй байна.	-	-Биет бус хөрөнгийг хүн, хуулийн этгээдээс, худалдан авахдаа тухайн хөрөнгийн эзэмших эрхийн талаарх заалтыг тендерийн баримт бичигт тусгаж байх.	2025 оны ХАА-ны төлөвлөгөөнд Дижитал аймаг-Дижитал хот ажлын даалгаврыг боловсруулан 7 аймагт нэвтрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Тендер шалгаруулалтын бичиг баримтад оюуны өмч, эх код, тайлбар, гарын авлагыг бүрэн хүлээлгэж өгөхөөр тусгаж, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан. 2025 оны төсвийн тодотголоор санхүүжилтийн эх үүсвэргүй болсон тул тус ажил тайлант онд хэрэгжээгүй	100%
4.	Төсвийн төслийн саналыг боловсруулахдаа хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний зардлыг	-		-Сангийн сайдаас 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/6731 дугаартай албан бичгээр ирүүлсэн Төсвийн	100%

	өмнөх онуудын гүйцэтгэлд суурилж, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөөгүй, арга хэмжээг ажил үйлчилгээ, тоо үзүүлэлтээр дэлгэрэнгүй ангилан бэлтгээгүй, бөөн дүнгээр төсөвлөсөн байна.		-Төсвийн саналыг боловсруулахдаа судалгаанд үндэслэн зардлын ангилал хэрэгжүүлэх арга хэмжээ бүрээр задлан бодитой боловсруулж байх	удирдамж, батлагдсан 2026 оны төсвийн хязгаарын дагуу төсвийн төслийг боловсруулж 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/1713 дугаартай албан бичгээр УИХТГ, Сангийн яам, Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлсэн.	
5.	Тайлант оны Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц /71302/ хөтөлбөрийн цахим шилжилт /80316/ арга хэмжээний батлагдсан төсвийн гүйцэтгэлээр бараа үйлчилгээний бусад зардлаас 8,034.3 мянган төгрөгийн тээвэр, шатахуун, 113,790.7 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан нь төсвийн хөтөлбөр, арга хэмжээний зардлын ангиллын бодит гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй байна.	121,825.0	-Хууль тогтоомжоор батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу төсвийн зарцуулалтыг санхүүжүүлж байх	Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц /71302/ хөтөлбөрийн цахим шилжилт /80316/ арга хэмжээний зардлаас тээвэр шатахуун, томилолтын зардлыг санхүүжүүлээгүй болно. Хөтөлбөр арга хэмжээний зардлыг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаа.	100%
	Нийт дүн	517,825.0 /Таван зуун арван долоон сая хоёр зуун наян долоон мянга			

ХЯНАСАН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

2025 оны 09 сарын 30 өдөр

П.ДЭЛГЭРМАА

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

2025 оны 09 сарын 30 өдөр

С.ЛХАМ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

2025 оны 09 сарын 30 өдөр

О.ЗОЛЗАЯА